

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлгийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/11/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот
2026 он

Санхүүгийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас:261885 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Ахлах аудитор: Э.Бат-Эрдэнэ
Утас:263533 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn
Мишээл-Од Аудит ХХК-ийн захирал: Т.Одончимэг
Утас:70169029 Цахим хаяг: info@misheelodaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	Error! Bookmark not defined.
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	8
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	10
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	12
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	16
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	16
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	16
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	17
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	17
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	19
4. АУДИТЫН ТАЙЛАН	21
4.1 Ерөнхий зүйл	21
4.2 Материаллаг байдал	21
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	21
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	21
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	24
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	24
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	26
5.2 Албан шаардлага	26
5.3 Зөвлөмж	27
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	30

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АШУУИС	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
НТШ	Нээлттэй тендер шалгаруулах
ОУБ	Олон улсын байгууллага
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮЭХ	Үйлдвэрчний эвлэлийн хороо
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгал үндэсний зөвлөл
ЭМЯ	Эрүүл мэндийн яам



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/392
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 1,112,086.2 мянган төгрөгийн зөрчил илэрч бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр авахаар нэхэмжилсэн санхүүжилтээс шинжилгээ оношилгооны бүрдэл дутуу, өвчтөн эмнэлгийн тусламж үйлчилгээ авч байх явцдаа өөр эмнэлгээр үйлчлүүлсэн, өвчний түүхийн бичилт шаардлага хангаагүй зэрэг зөрчилтэй асуудлаас шалтгаалан тусламж үйлчилгээний чанарын хяналтаар 196,143.1 мянган төгрөгийн санхүүжилт хасагдсан;
- Эмнэлгийн хэрэгсэл худалдан авах 469,213.1 мянган төгрөгийн тендерийн батлагдсан төсөвт өртгийг хувааж, сонгон шалгаруулсан зэрэг зөрчлүүд нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд Австрали, Япон, Бүгд Найрамдах Солонгос Улсын дэлхийд нэр хүндтэй, чадварлаг эмч мэргэжилтнүүдээс туршлага судлах, ажлын байрны сургалтыг зохион байгуулж, 30,000.0 орчим мянган төгрөгийн epilepsi, ходоодны хорт хавдрын дурангийн мэс засал хийж, 120,000.0 мянган төгрөгийн нүдний өвчний лазер оношилгооны тоног төхөөрөмжийг хандиваар хүлээн авсан байна. Шинээр нэвтрүүлсэн технологийн хүрээнд дүрс оношилгоо, мэдээгүйжүүлгийн чиглэлээр давхардсан тоогоор 80 орчим эмч, багш, 100 орчим резидент эмч нар гадаад, дотоодод суралцсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Дэлхийн банкны төслийн хүрээнд 2023 онд хүлээн авсан лабораторийн 2 тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгөд бодит үнэ цэнээр нь бүртгээгүй, үнийн дүнгүйгээр, тоо ширхгээр бүртгэснээр санхүүгийн тайлан бодитой, үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх эрсдэлтэй байна байна.

Бусад асуудал

Тус эмнэлэг нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлын хэсгийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *В. Р.* Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	18,004,150,875.43	17,225,431,050.42
31	Мөнгөн хөрөнгө	489,845,348.00	2,471,947,992.08
31100	Кассанд байгаа мөнгө	268,400.00	15,501,000.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	481,948,048.00	2,450,408,492.08
31400	Замд яваа мөнгө	7,628,900.00	6,038,500.00
33	АВЛАГА	7,681,713,467.39	3,275,447,093.28
33100	Ажиллагчидтай холбоотой авлага	175,596.39	1,947,553.60
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	41,403,400.00	26,813,100.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	7,636,225,167.00	3,175,170,402.68
33500	Бусад авлага	3,909,304.00	71,516,037.00
3351	Байгууллагаас авах авлага	2,514,304.00	71,150,037.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,395,000.00	366,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	9,832,592,060.04	11,478,035,965.06
35100	Түүхий эд материал	8,626,002,168.61	10,272,670,186.40
35110	Тусгай зориулалттай материал	4,812,486,781.05	4,907,232,127.68
35130	Эм, боох материал	3,813,515,387.56	5,365,438,058.72
35400	Хангамжийн материал	1,206,589,891.43	1,205,365,778.66
35410	Бичиг хэргийн материал	93,638,391.65	48,986,274.03
35420	Аж ахуйн материал	77,819,054.51	47,523,849.00
35430	Сэлбэг хэрэгсэл	88,148,859.41	199,887,343.00
35440	Түлш, шатах тослох материал	3,640,000.00	12,700,000.00
35450	Барилгын засварын материал	838,650.00	7,060,900.00
35460	Хүнсний материал	21,731,698.39	51,688,597.88
35470	Бусад хангамжийн материал	920,773,237.47	837,518,814.75
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	177,676,576,116.07	170,762,815,176.24
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	177,676,576,116.07	170,762,815,176.24
39200	Биет хөрөнгө	177,544,837,901.19	170,675,032,349.56
39201	Барилга, байгууламж, орон сууц	166,036,081,200.00	166,036,081,200.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(10,377,255,074.85)	(13,144,523,094.81)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	801,034,112.16	801,034,112.16
39204	Хуримтлагдсан элэгдэл	(136,909,621.71)	(217,340,585.94)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	55,114,308,293.44	56,601,376,781.46
39206	Хуримтлагдсан элэгдэл	(34,759,375,027.26)	(40,282,795,873.63)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,702,310,321.00	1,903,479,845.42
39208	Хуримтлагдсан элэгдэл	(863,035,468.24)	(1,046,309,201.71)
39214	Бусад үндсэн хөрөнгө	29,200,000.00	29,200,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,520,833.35)	(5,170,833.39)
39300	Биет бус хөрөнгө	131,738,214.88	87,782,826.68
39301	Програм хангамж	204,084,230.00	210,826,658.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(93,894,882.37)	(125,622,552.82)
39303	Бусад биет бус хөрөнгө	74,900,898.00	68,158,470.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(53,352,030.75)	(65,579,748.50)
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	195,680,726,991.50	187,988,246,226.66
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,963,632,192.89	3,230,676,959.95
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,963,632,192.89	3,230,676,959.95
41300	Өглөг	98,081,069.05	309,133,256.01
41310	Ажиллагчидтай холбогдсон өглөг	98,081,069.05	309,133,256.01
41360	Бусад өглөг	3,865,551,123.84	2,921,543,703.94
41361	Байгууллагад өгөх өглөг	3,859,776,123.84	2,918,520,631.94
41362	Хувь хүмүүст өгөх өглөг	5,775,000.00	3,023,072.00
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ, ӨМЧИЙН ДҮН	191,717,094,798.61	184,757,569,266.71

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлгийн
2025 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

51	Засгийн газрын хувь оролцоо	-	166,036,081,200.00
51101	Засгийн газрын оруулсан капитал	-	166,036,081,200.00
51200	Хуримтлагдсан үр дүн	191,099,535,342.28	18,079,832,780.88
51210	Өмнөх үеийн үр дүн	195,268,768,865.87	25,039,358,313.66
51220	Тайлант үеийн үр дүн	(4,169,233,523.59)	(6,959,525,532.78)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	617,559,456.33	641,655,285.83
VIII	НИЙТ ӨР ТӨЛБӨР ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	195,680,726,991.50	187,988,246,226.66

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	32,212,236,291.34	29,193,442,035.09
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,962,437,268.34	7,148,510,544.09
120	Нийтлэг татварын бус орлого	4,443,476,307.23	4,127,203,255.76
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,241,154,731.74	3,913,934,996.44
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,095,305,540.00	3,778,394,996.44
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	145,849,191.74	135,540,000.00
120005	Түрээсийн орлого	75,297,600.00	92,577,600.00
120009	Бусад орлого	127,023,975.49	120,690,659.32
122	Тусламжийн орлого	8,850,260,961.11	5,137,935,388.33
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,933,568,498.52	284,566,670.44
122001	Хандив тусламж /дотоод	1,585,392,462.59	2,736,740,617.89
12211	Урсгал санхүүжилтийн орлого	2,256,300,000.00	2,116,628,100.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	75,000,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	18,918,499,023.00	19,928,303,391.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	18,918,499,023.00	19,928,303,391.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	18,918,499,023.00	19,928,303,391.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	36,381,469,814.93	36,152,967,567.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	36,381,469,814.93	36,152,967,567.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	36,333,678,031.16	36,065,650,747.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	11,024,035,488.62	12,333,905,868.27
210101	Үндсэн цалин	6,501,039,370.16	7,208,829,749.29
210102	Нэмэгдэл	3,661,753,514.96	4,219,645,953.38
210103	Унаа хоолны хөнгөлөлт	845,835,000.00	873,003,000.00
210104	Урамшуулал	15,407,603.50	32,427,165.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,435,099,962.16	1,599,171,664.66
210201	Тэтгэврийн даатгалын зардал	1,435,099,962.16	1,599,171,664.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	985,615,640.23	1,080,003,382.21
210301	Гэрэл, цахилгаан	670,801,866.11	802,743,159.18
210302	Түлш, халаалт	76,849,992.40	65,697,247.35
210303	Цэвэр, бохир ус	237,963,781.72	211,562,975.68
2104	Хангамж, бараа материалын зардал	1,374,531,744.49	727,677,291.15
210401	Бичиг хэрэг	206,046,761.93	179,070,813.12
210402	Тээвэр, шатахуун	31,395,000.00	25,935,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	42,720,368.97	46,855,999.30
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	177,195,916.79	37,120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	315,041,113.15	227,271,933.51
210408	Бараа материал акталсны зардал	602,132,583.65	211,423,545.22
2105	Нормативт зардал	9,560,405,665.77	10,627,317,624.32
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,231,087,342.88	10,233,318,571.31
210502	Хоол хүнс	329,318,322.89	393,999,053.01
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	641,544,742.41	486,627,716.41
210604	Урсгал засвар	641,544,742.41	486,627,716.41
2107	Томилолт, зочны зардал	118,362,340.40	11,683,695.20
210701	Гадаад албан томилолт	104,980,340.40	10,663,695.20
210702	Дотоод албан томилолт	13,382,000.00	1,020,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	499,660,364.42	568,782,552.91

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлгийн
2025 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	485,749,881.42	553,267,426.91
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	12,000,000.00	12,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	776,483.00	2,484,226.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,134,000.00	1,030,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,694,422,082.66	8,630,480,952.27
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26,840,000.00	28,482,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	10,667,582,082.66	8,601,998,952.27
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,791,783.77	87,316,820.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	47,791,783.77	87,316,820.47
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	44,541,783.77	60,372,653.47
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,250,000.00	26,944,167.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(4,169,233,523.59)	(6,959,525,532.78)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	(4,169,233,523.59)	(6,959,525,532.78)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	23,038,728,256.89	30,583,444,203.24
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,337,707,325.89	3,991,489,855.92
120	Нийтлэг татварын бус орлого	4,337,707,325.89	3,991,489,855.92
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,138,411,240.00	3,784,439,637.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,138,411,240.00	3,784,439,637.00
120002	Хүүгийн орлого	-	11,159.44
120005	Түрээсийн орлого	65,696,400.00	43,809,600.00
120009	Бусад орлого	133,599,685.89	163,229,459.48
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	18,701,020,931.00	26,591,954,347.32
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,256,300,000.00	1,763,856,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,256,300,000.00	1,763,856,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	75,000,000.00	-
131104	Нэмэлт санхүүжилт	75,000,000.00	-
1330	Төсвийн захирагчдаас	-	352,771,400.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	352,771,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	16,369,720,931.00	24,475,326,247.32
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	83,092.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	16,369,720,931.00	24,475,243,155.32
II	НИИТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	22,630,693,797.50	27,273,420,247.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	22,630,693,797.50	27,273,420,247.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,582,902,013.73	27,186,103,426.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,987,045,933.69	12,118,259,928.13
210101	Үндсэн цалин	10,987,045,933.69	8,226,258,951.62
210102	Нэмэгдэл	-	2,760,945,507.25
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	738,012,514.45
210104	Урамшуулал	-	393,042,954.81
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,426,526,016.53	1,582,873,489.65
210201	Тэтгэврийн даатгалын зардал	988,003,298.69	1,087,291,300.00
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	102,924,500.31	115,249,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	72,783,635.48	91,339,806.82
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	46,773,649.90	52,702,895.79
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	216,040,932.15	236,290,087.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	985,615,640.23	1,080,000,962.21
210301	Гэрэл, цахилгаан	670,801,866.11	802,523,159.18
210302	Түлш, халаалт	76,849,992.40	65,697,247.35
210303	Цэвэр, бохир ус	237,963,781.72	211,780,555.68
2104	Хангамж, бараа материалын зардал	699,848,509.97	660,316,302.80
210401	Бичиг хэрэг	219,373,036.00	112,548,067.50
210402	Тээвэр, шатахуун	33,107,304.00	35,192,696.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	42,545,168.97	47,251,199.30
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	122,993,995.00	144,948,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	281,829,006.00	320,376,140.00
2105	Нормативт зардал	7,232,805,892.49	10,100,880,221.12
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,723,191,752.49	9,592,151,296.82
210502	Хоол хүнс	353,592,140.00	405,282,424.30
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	156,022,000.00	103,446,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	608,506,330.00	1,010,605,937.20

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлгийн
2025 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210601	Багаж, техник, хэрэгсэл	51,822,320.00	226,234,608.00
210602	Тавилга	-	59,843,830.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	10,930,000.00	-
210604	Урсгал засвар	545,754,010.00	724,527,499.20
2107	Томилолт, зочны зардал	118,362,340.40	11,683,695.20
210701	Гадаад албан томилолт	104,980,340.40	10,663,695.20
210702	Дотоод албан томилолт	13,382,000.00	1,020,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	497,351,350.42	593,000,890.38
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	483,363,867.42	563,056,766.38
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	12,000,000.00	12,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	13,953,998.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	776,483.00	2,784,226.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	165,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,134,000.00	1,040,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,840,000.00	28,482,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26,840,000.00	28,482,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,791,783.77	87,316,820.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	47,791,783.77	87,316,820.47
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	44,541,783.77	60,372,653.47
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,250,000.00	26,944,167.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	408,034,459.39	3,310,023,956.08
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	585,657,800.00	1,327,921,312.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	585,657,800.00	1,327,921,312.00
2200	Дотоод эх үүсвэрээр	585,657,800.00	1,327,921,312.00
221001	Их засвар	88,300,000.00	-
222001	Тавилга эд хогшил	33,307,000.00	-
222002	Техник хэрэгсэл, багаж тоног төхөөрөмж	414,050,800.00	142,763,800.00
223001	Бусад хөрөнгө	50,000,000.00	-
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	1,185,157,512.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(585,657,800.00)	(1,327,921,312.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(177,623,340.61)	1,982,102,644.08
IX	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,666,537.00	489,845,348.00
X	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	489,845,348.00	2,471,947,992.08

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	1.1 Засгийн газрын оруулсан капитал	1.2 Дахин үнэлгээний нөөц	1.3 Хуримтлагдсан ҮР ДҮН	1.4 Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	617,559,456.33	195,268,768,865.87	195,886,328,322.20
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(4,169,233,522.71)	(4,169,233,522.71)
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	617,559,456.33	191,099,535,343.16	191,717,094,799.49
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	166,036,081,200.00	-	(166,060,177,029.50)	(24,095,829.50)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	24,095,829.50	-	24,095,829.50
Тайлант үеийн үр дүн	-	-	(6,959,525,532.78)	(6,959,525,532.78)
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	166,036,081,200.00	641,655,285.83	18,079,832,780.88	184,757,569,266.71

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	31,041,569,222.00	30,583,433,043.80	702,156,178.20	98.5
12	Татварын бус орлого	-	163,229,459.48	(163,229,459.48)	-
120	Нийтлэг татварын бус орлого	-	163,229,459.48	(163,229,459.48)	-
120009	Бусад орлого	-	163,229,459.48	(163,229,459.48)	-
1200042	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	3,718,335,122.00	3,706,239,237.00	12,095,885.00	39.8
12000427	Үзлэгийн орлого	3,649,215,122.00	3,662,429,637.00	(13,214,515.00)	-
12000421	Түрээсийн орлого	69,120,000.00	43,809,600.00	25,310,400.00	63.4
120004213	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	-	122,010,000.00	122,010,000.00	-
120004213	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	-	122,010,000.00	122,010,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,650,996,800.00	2,116,628,100.00	534,368,700.00	79.8
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,170,000,000.00	1,763,856,700.00	406,143,300.00	81.3
131009	Урьд оны төсвийн хэмнэлтийн орлого	480,996,800.00	-	480,996,800.00	-
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	352,771,400.00	(352,771,400.00)	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	24,672,237,300.00	24,475,326,247.32	196,911,052.68	99.2
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	83,092.00	(83,092.00)	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	24,672,237,300.00	24,475,243,155.32	196,994,144.68	99.2
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	31,041,569,239.00	28,601,341,559.16	2,440,227,679.84	92.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	30,890,234,637.00	27,186,103,426.69	3,704,131,210.31	88.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	30,890,234,637.00	27,186,103,426.69	3,704,131,210.31	88.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	12,404,900,600.00	12,118,259,928.13	286,640,671.87	97.7
210101	Үндсэн цалин	12,404,900,600.00	8,226,258,951.62	4,178,641,648.38	66.3
210102	Нэмэгдэл	-	2,760,945,507.25	(2,760,945,507.25)	-
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	738,012,514.45	(738,012,514.45)	-
210104	Урамшуулал	-	393,042,954.81	(393,042,954.81)	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,586,080,300.00	1,582,873,489.65	3,206,810.35	99.8
210201	Тэтгэврийн даатгал	1,087,291,300.00	1,087,291,300.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	115,249,400.00	115,249,400.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	92,165,400.00	91,339,806.82	825,593.18	99.1

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлгийн
2025 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210204	Ажилгүйдлийн даатгал	53,208,000.00	52,702,895.79	505,104.21	99.1
210205	Эрүүл мэндийн даатгал	238,166,200.00	236,290,087.04	1,876,112.96	99.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,498,454,234.00	1,080,000,962.21	418,453,271.79	72.1
210301	Гэрэл, цахилгаан	958,887,000.00	802,523,159.18	156,363,840.82	83.7
210302	Түлш, халаалт	189,215,000.00	65,697,247.35	123,517,752.65	34.7
210303	Цэвэр, бохир ус	350,352,234.00	211,780,555.68	138,571,678.32	60.5
2104	Хангамж, бараа материалын зардал	753,935,203.00	660,316,302.80	93,618,900.20	87.6
210401	Бичиг хэрэг	145,159,800.00	112,548,067.50	32,611,732.50	77.5
210402	Тээвэр, шатахуун	40,252,000.00	35,192,696.00	5,059,304.00	87.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	59,707,100.00	47,251,199.30	12,455,900.70	79.1
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	144,309,703.00	144,948,200.00	(638,497.00)	100.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	364,506,600.00	320,376,140.00	44,130,460.00	87.9
2105	Нормативт зардал	11,065,239,400.00	10,100,880,221.12	964,359,178.88	91.3
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,431,101,900.00	9,592,151,296.82	838,950,603.18	92.0
210502	Хоол хүнс	541,974,100.00	405,282,424.30	136,691,675.70	74.8
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	92,163,400.00	103,446,500.00	(11,283,100.00)	112.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,715,573,000.00	1,010,605,937.20	1,704,967,062.80	37.2
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,261,249,100.00	226,234,608.00	1,035,014,492.00	17.9
210602	Тавилга	136,209,900.00	59,843,830.00	76,366,070.00	43.9
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	31,944,600.00	-	31,944,600.00	-
210604	Урсгал засвар	1,286,169,400.00	724,527,499.20	561,641,900.80	56.3
2107	Томилолт, зочны зардал	50,000,000.00	11,683,695.20	38,316,304.80	23.4
210701	Гадаад албан томилолт	20,000,000.00	10,663,695.20	9,336,304.80	53.3
210702	Дотоод албан томилолт	30,000,000.00	1,020,000.00	28,980,000.00	3.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	787,001,900.00	593,000,890.38	194,001,009.62	75.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	733,690,700.00	563,056,766.38	170,633,933.62	76.7
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	20,000,000.00	12,000,000.00	8,000,000.00	60.0
210803	Даатгалын үйлчилгээ	17,296,000.00	13,953,998.00	3,342,002.00	80.7
210804	Тээврийн хэрэгслийн татвар	5,806,200.00	2,784,226.00	3,021,974.00	48.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	209,000.00	165,000.00	44,000.00	79.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	10,000,000.00	1,040,900.00	8,959,100.00	10.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,050,000.00	28,482,000.00	568,000.00	98.0

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлгийн
2025 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	29,050,000.00	28,482,000.00	568,000.00	98.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	151,334,602.00	87,316,820.47	64,017,781.53	57.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	151,334,602.00	87,316,820.47	64,017,781.53	57.7
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,550,000.00	-	16,550,000.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	118,697,102.00	60,372,653.47	58,324,448.53	50.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,087,500.00	26,944,167.00	(10,856,667.00)	167.5
220	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДАЛ	-	1,327,921,312.00	(1,327,921,312.00)	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	1,327,921,312.00	(1,327,921,312.00)	-
222002	Техник хэрэгсэл, багаж тоног төхөөрөмж	-	142,763,800.00	(142,763,800.00)	-
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	1,185,157,512.00	(1,185,157,512.00)	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	419	419	-	100.0
620001	Удирдах ажилтан	5	5	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	322	309	(13)	96.0
620003	Үйлчлэх ажилтан	92	105	13	114.1

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн харьяа Монгол-Японы эмнэлэг нь үйл ажиллагаагаа 2019 оноос эхлэн явуулж эхэлсэн бөгөөд Япон Улсын Засгийн Газрын буцалтгүй тусламжаар баригдаж, олон улсын стандартад нийцсэн, орчин үеийн дэд бүтэц, тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон байна.

Тус эмнэлэг нь эрхэм зорилгоо “Улсын хэмжээнд төрөлжсөн мэргэшлээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанартай хүртээмжтэй үзүүлэх, оношилгоо, эмчилгээний шинэ технологийг нэвтрүүлэх, сургалт, судалгаа, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг цогцоор нь үзүүлнэ” гэж тодорхойлсон.

Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн Монгол-Японы эмнэлэг нь дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Төрөлжсөн мэргэжил, их сургуулийн эмнэлгийн түвшний эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх;
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд Япон менежмент, стандарт, технологийг нутагшуулах
- Эрүүл мэндийн салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх нотолгоонд суурилсан оношилгоо, эмчилгээний шинэлэг арга зүй, технологи, инновацыг практикт нэвтрүүлэх;
- Монгол Улсад оношлох, эмчлэх боломжгүй өвчний оношилгоо, эмчилгээний аргыг нэвтрүүлэх, нутагшуулах, хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;
- Эмнэлэгт суурилсан сургалтын тогтолцоог хөгжүүлж, бүх шатны сургалтын үйл ажиллагааг технологи, стандартын дагуу зохион байгуулах;
- Эрдэм шинжилгээ, эмнэл зүйн туршилт судалгааны ажил эрхлэх;
- Нийгмийн эрүүл мэндийн тэргүүлэх чиглэлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх;
- Иргэдэд эрүүл мэндийн боловсролыг олгох, эрүүл амьдралын хэвшил тогтоох, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах;
- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, үндэсний болон олон улсын стандартыг мөрдлөг болгон ажиллах;

Эмнэлгийн 2025-2029 оны стратеги төлөвлөгөө боловсруулан Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулсан байна.

АШУҮИС-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь тус эмнэлгийн төсвийг батлан эрүүл мэндийн байгууллагуудын гүйцэтгэлд суурилсан төвийн зарцуулалтын тогтолцоог хэрэгжүүлэн ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус эмнэлэг нь Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад хууль, эрх зүйн актын хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын сангийн хуульд өөрчлөлт орж 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрөөс мөрдөн ажиллаж байна;
- Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.5 дах хэсэгт 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт орсон;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон;
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”;
- Эрүүл мэндийн яам нь 2025-2028 онд хэрэгжүүлэх “Цахим эрүүл мэнд” цогц арга хэмжээний төлөвлөгөөг баталсан;
- Урьдчилан сэргийлэх, өвчний илрүүлэлт, тусламж үйлчилгээний бодлого Эмэгтэйчүүдийн хөхний хорт хавдрыг урьдчилан илрүүлэх, дархлаажуулах ажлыг эрчимжүүлэх хөтөлбөр хэрэгжиж байна;
- Эрүүл мэндийн санхүүжилт, даатгалын нөхцөл ЭМДҮЗ-ийн 2025 оны 4 дүгээр тогтоол батлагдан 3 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн;
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний программ хангамжид тавигдах шаардлагыг тогтоох, үнэлгээ хийх, шаардлагад нийцсэн программ хангамжийг мэдээлэх журам баталсан.

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлэг нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус эмнэлэг нь Боловсрол шинжлэх ухааны яамнаас бэлтгэсэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байгаа ч байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулсан, шинэчлэгдсэн заавар, журмыг тусгасан өөрчлөлтүүд хийгдэх шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,692,480.8 мянган төгрөгөөр буюу 3.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	489,845.3	2,471,948.0	1,982,102.7
Авлага	7,681,713.5	3,275,447.1	(4,406,266.4)
Бараа материал	9,832,592.1	11,478,036.0	1,645,443.9
Үндсэн хөрөнгө	177,676,576.1	170,762,815.1	(6,913,761.0)
Нийт хөрөнгө	195,680,727.0	187,988,246.2	(7,692,480.8)
Өр төлбөр	3,963,632.2	3,230,677.0	(732,955.2)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	191,717,094.8	184,757,569.2	(6,959,525.6)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	195,680,727.0	187,988,246.2	(7,692,480.8)

Дээрх хүснэгтээс харахад дансны үлдэгдэлд нөлөө бүхий дараах өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 1,982,102.7 мянган төгрөгөөр өссөн нь 2026 оны эхний санхүүжилт оройтож ордогтой холбоотойгоор 1 дүгээр сарын цалингийн зардал болон яаралтай тусламжийн үед ашиглах хөрөнгийн эх үүсвэрийн мөнгийг дансанд үлдээсэн, 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдөр 705,542.5 мянган төгрөгийн татаас санхүүжилтийн орлогыг хүлээн авсан зэргээс шалтгаалсан;
- Авлага дансны үлдэгдэл 4,406,266.4 мянган төгрөгөөр буурсан нь Эрүүл мэндийн даатгалын сангаас хүлээн авах төлбөртэй үйлчилгээний өмнөх оны авлагын 4,461,054.7 мянган төгрөг төлөгдсөнтэй холбоотой;
- Бараа материал дансны үлдэгдэл 1,645,443.9 мянган төгрөгөөр өссөн нь томуу, томуу төст өвчний дэгдэлт болон яаралтай тусламжийн үед шаардагдах нөөцийг нөхөн бүрдүүлсэнтэй холбоотойгоор эм эмнэлгийн хэрэгсэл, болон бусад бараа материалын худалдан авалт нэмэгдсэнтэй холбоотой;
- Үндсэн хөрөнгийн дансны өмнөх оны үлдэгдэл 6,913,761.0 мянган төгрөгөөр буурсан нь 1,383,771.3 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан мөн хандиваар 284,566.7 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авснаар нэмэгдэж, 8,601,998.9 мянган төгрөгийн тайлант хугацааны элэгдлийн зардлаар буурсантай холбоотой;
- Өр төлбөрийн үлдэгдэл 732,955.2 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх хугацаанд үүссэн бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын хуримтлагдсан өр төлбөрийг төлж барагдуулсантай холбоотой;
- Засгийн газрын хувь оролцоо данс тайлант үеийн үр дүн 6,959,525.6 мянган төгрөгөөр буурсан;

Судалгааны үр дүн: Тус эмнэлгийн биет бус хөрөнгөд бүртгэлтэй 2019 он, 2020 онуудад худалдан авч, ашиглаж байгаа 28,798.0 мянган төгрөгийн өртөгтэй санхүүгийн программ, 5,000.0 мянган төгрөгийн өртөгтэй хүний нөөцийн программ, 6,900.0 мянган төгрөгийн өртөгтэй дүрс оношилгооны иж бүрэн систем, 109,020.0 мянган төгрөгийн өртөгтэй компьютерт томографийн программ, 4,900.0 мянган төгрөгийн өртөгтэй бичиг хэргийн удирдлагын программ, 49,466.2 мянган төгрөгийн өртөгтэй хяналтын камерын лиценз, 49,955.7 мянган төгрөгийн өртөгтэй сүлжээний аюулгүй байдлын төхөөрөмжийн лиценз, 18,202.7 мянган төгрөгийн өртөгтэй сервер

компьютерын үйлдлийн систем лиценз, 6,742.4 мянган төгрөгийн өртөгтэй Вэб сайт, нийт 978,985.0 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Дээрх программ хангамжуудын жилийн ашиглалтын зардалд нийт 44,418.0 мянган төгрөгийн төлбөр төлж байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 25,988,789.2 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 3,836,519.4 мянган төгрөг нийт 29,825,308.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 2,116,638.5 мянган төгрөгөөр бууруулж 27,708,670.1 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь хангамжийн бараа материалын зардал болон нормативт зардлыг төсвийн төслөөс бууруулж баталсантай холбоотой байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 3,332,899.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг улсын төсвөөс 2,170,000.0 мянган төгрөг, нийгмийн даатгалын сангаас 24,672,237.3 мянган төгрөг, бусад эх үүсвэрээс 480,996.8 мянган төгрөг, өөрийн үйл ажиллагааны орлогоос 3,718,335.1 мянган төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр тооцож нийт 31,041,569.2 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэн зарцуулахаар төлөвлөсөн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,116,628.1 мянган төгрөг, нийгмийн даатгалын сангаас 24,475,326.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлого 3,991,489.9 мянган төгрөгийг бүрдүүлж, нийт 30,583,444.2 мянган төгрөгийг төвлөрүүлснээс 28,601,341.6 мянган төгрөгийг зарцуулж, 2,471,948.0 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 28,601,341.5 мянган төгрөг буюу 92.1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 2,440,227.6 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	71803-Дээд боловсрол	31,041,569.2	28,601,341.6	2,440,227.6	92.1
1	81834-Боловсролын стандарт, сургалт	31,007,164.3	28,566,936.7	2,440,227.6	92.1
2	83601-Нэмэлт-Олон Улсын байгууллагаас олгосон	34,404.9	34,404.9	-	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Судалгааны үр дүн: Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу аудитын явцад тус байгууллагаас дараах зардлын судалгааг авч, үр дүнг дүгнэлээ. Тухайлбал:

- Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлэг нь 2025 онд 12 орон тоог хавсран ажилласнаас шалтгаалан орон тооны 9.0 хувийн цомхотголыг хэрэгжүүлээгүй;
- АШУҮИС болон ҮЭХ-ны 2023 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн хамтын гэрээгээр ажлын нэг өдрийн хоолны нөхөх төлбөрийг 4.0 мянган төгрөгөөр, унааны нөхөх төлбөрийг 6.0 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант оны батлагдсан төсөв 868,254.5 мянган төгрөг, гүйцэтгэлээр 738,012.5 мянган төгрөг зарцуулж байна.
- Гадаад томилолтын зардалд 20,000.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 10,664.0 мянган төгрөг, гадаад зочин хүлээн авах арга хэмжээнд бараа үйлчилгээний бусад зардлаас 2,728.0 мянган төгрөгийн зардал гарсан байна. Энэ нь жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг эрдэм шинжилгээний хурлаар Каназава их сургуулийн төлөөлөгчдийн айлчлалтай холбоотой;
- Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 29,050.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 28,482.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Дээрх сургалт, семинарыг явуулснаар эмчилгээ оношилгооны шинэ арга зүй, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын стандарт, багийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж сайжирсан;
- Тайлант онд хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээ байгуулаагүй;
- Төрд учирсан хохиролтой холбоотой зардал болон авлага бүртгэгдээгүй;

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 11,349,588.0 мянган төгрөгөөр баталсан байна. Батлагдсан төлөвлөгөөг 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдөр эмнэлгийн хэрэгсэл, эм бэлдмэл, лабораторийн урвалж, бодис худалдан авахаар 1,526,776.1 мянган төгрөгөөр төсвийг нэмэгдүүлэн 12,876,364.1 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна.

Төлөвлөгөөнд нээлттэй тендер шалгаруулалтын аргаар худалдан авах 11,384,970.0 мянган төгрөгийн 17 тендер, харьцуулалтын аргаар худалдан авах 450,324.1 мянган төгрөгийн 8 тендер, ерөнхий гэрээний аргаар худалдан авах 1,041,067.0 мянган төгрөгийн 5 тендер тусгагдсанаас гүйцэтгэлээр НТШ болон харьцуулалтын аргаар 11,561,686.2 мянган төгрөг, ерөнхий гэрээний аргаар 965,532.9 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авсан.

Япон улсын эзэн хааны төрийн айлчлалтай холбоотой 82,191.6 мянган төгрөгийн засвар, эмнэлгийн магадлан итгэмжлэлтэй холбоотой 27,764.4 мянган төгрөг, эмнэлгийн үйл ажиллагааг тасалдуулахгүй байх мөн томуу, томуу төст өвчний дэгдэлттэй холбоотой яаралтай нөхцөл байдал үүссэн тул нэмэлтээр 16 хүүхдийн ор дэлгэн эмчилгээ, үйлчилгээнд хэрэгцээтэй эм бэлдмэлд нийт 550,092.9 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн Монгол-Японы эмнэлгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн Монгол-Японы эмнэлэг, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Мишээл-Од аудит ХХК-ийн ахлах аудитор М.Цэнд-Аюуш, аудитор П.Энхцэлмэг нар гүйцэтгэж, гүйцэтгэх захирал Т.Одончимэг, Чанарын хяналтын менежер Э.Энхцэцэг нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Э.Бат-Эрдэнэ, аудитын менежер С.Нацагдорж, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн Монгол-Японы эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 01/61 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийн тодотгосон төлөвлөгөөний нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсвийн тодотгосон төлөвлөгөөний нийт зардлын 30,118,360.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 301,183.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төсвийн зардлыг батлагдсан хуваарийн дагуу сахилга баттай зарцуулж, урсгал зардлыг бууруулан, гадаад болон дотоод томилолтын зардлыг хэмнэсэн. Мөн эмнэлгийн ачаалал өмнөх оноос ихэссэн боловч орон тоонд өөрчлөлт оруулалгүйгээр давхар үүрэг гүйцэтгэх зохион байгуулалт хийж томилолтын зардлыг тэвчих зэрэг арга хэмжээ авч ажилласан ба хуулийн хэрэгжилтийн хүрээнд хязгаарласан 32 заалтуудыг хамруулан горим сорил хэрэгжүүлсэн, аудитаар зөрчил илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 390,128.0 мянган төгрөгийн зөрчлөөс 129,415.5 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 260,712.5 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 153 мэдээллээс 147 мэдээллийг хуулийн хугацаанд иж бүрэн оруулсан бөгөөд 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна. Мөн Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 14 удаагийн 98,701.7 мянган төгрөгийн орлого, 15 удаагийн 162,010.8 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ, мөн “Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг” зэргийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 4.1.1 “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2 “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралт “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2.10 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хуулбарын хамт тухайн гүйлгээ хийгдсэнээс хойш 7 хоногийн дотор энэ журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй зөрчлийг таслан зогсоож, мэдээллийг хуулийн хугацаанд иж бүрэн, үнэн зөв байршуулж, давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлагдсан маягтаар бэлтгээгүй, тендерийн баримт бичигт шалгарсан оролцогчийн тендерт ирүүлсэн материалыг хавсаргаагүй, шалгараагүй оролцогчдын материалыг давхардуулан их хэмжээгээр хувилж хавсарган төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4 “цахим гарын үсэг, цахим шуудан ашиглах зэргээр албан бичиг боловсруулах, илгээх үйл явцыг хялбаршуулж бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хор, шуудан хүргэлтийн зардлыг хэмнэх”, Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаал “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-аар баталсан төлөвлөгөө

тайлангийн хавсралт маягтууд, 2023 оны А/255 дугаар тушаал “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”, 2023 оны А/254 дүгээр тушаал “Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам”-ын 2.14 “Үнэлгээний хорооны гишүүн хуулийн 52.1-т заасан үүргийг дараах байдлаар хэрэгжүүлнэ. Үүнд: 2.14.1.үнэлгээний хорооны гишүүнээр томилогдохоос өмнө, эсхүл томилогдсон даруйд Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийн загварын дагуу тухайн худалдан авах ажиллагаанд оролцоход ашиг сонирхлын зөрчилтэй эсэхээ мэдэгдэх” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлагдсан маягтаар бэлтгээгүй, бичиг хэргийн үргүй зардал гаргасан зэрэг зөрчлүүдийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

2. Тендер шалгаруулалтын баримт бичигт бараа нийлүүлэх хугацааг 14-21 хоногоор заасан боловч гэрээ байгуулахдаа хугацааг 1 жилээр болгон өөрчилж, батлагдсан тендерийн баримт бичгийг мөрдөж ажиллаагүй, тоног төхөөрөмж хүлээн авсан комиссын актыг гэрээ дүгнэсэн актад хавсаргаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 “Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, захиалагч батална, 11.12 “Тендер шалгаруулалтын баримт бичигт өөрчлөлт оруулсан тухай бүрд цахим системийн холбогдох хэсэгт өөрчлөлтийг тусгана” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг тендерийн баримт бичигт заасны дагуу гүйцэтгээгүй, гэрээний биелэлтийг дүгнээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

3. Эмнэлгийн тавилга, эд хогшил худалдан авах 129,415.5 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй тендерийг үнэлэхдээ ажлын 5 хоногийн дотор дуусгавар болгох байтал тендер нээснээс хойш 7-18 хоногийн дараа үнэлж, сонгон шалгаруулалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2 “Үнэлгээний хороо тендер нээсэн өдөр тендер хянан үзэх, үнэлэх ажиллагааг эхлүүлнэ”, Сангийн сайдын 2023 оны А/255 дугаар тушаалын хавсралт “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ын 1.6 “Захиалагч тендер шалгаруулалтыг хуулийн хугацаанд багтаан хурдан шуурхай зохион байгуулахын тулд тендерийг хянан үзэх, үнэлэх ажиллагааг тендер нээсэн өдөрт нь багтаан эхлүүлж, ажлын таван өдрийн дотор дуусгавар болгох зарчмыг баримтална” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тендерийн үнэлгээг хуульд заасны дагуу тендер нээсэн өдрөөс эхэлж үнэлдэггүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 улирлын санхүүгийн тайланг хамруулж, өмнөх оны зөвлөмжийн биелэлт, мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, цалин хөлс, татварын бүртгэл, өглөг, авлагын данстын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа. Завсрын аудитаар 191,009,446.7 мянган төгрөгийн 16 алдааг залруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар 301,685.9 мянган төгрөгийн 3 зөрчлийг арилгах албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 1,913.9 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгснөөс тайлант онд, 1 албан шаардлага, 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	301,685.9	2	301,685.9	66.7
Зөвлөмж	4	1,913.9	3	1,913.9	75.0
Нийт дүн	7	303,599.9	5	303,599.9	71.4

Өмнөх оны аудитаар үндсэн хөрөнгийн дансанд бодит үнэ цэнээр нь бүртгээгүй хөрөнгүүдийг холбогдох газарт уламжлан үнэлж, бүртгэлд тусгах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй тул тайлант онд тус зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр авахаар нэхэмжилсэн санхүүжилтээс шинжилгээ оношилгооны бүрдэл дутуу, өвчтөн эмнэлгийн тусламж үйлчилгээ авч байх явцдаа өөр эмнэлгээр үйлчлүүлсэн, өвчний түүхийн бичилт шаардлага хангаагүй зэрэг зөрчилтэй асуудлаас шалтгаалан тусламж үйлчилгээний чанарын хяналтаар өмнөх онд 366,565.1 мянган төгрөгийн санхүүжилт хасагдсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн боловч тайлант онд 196,143.1 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргасан зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлээ.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлгийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн анхаарал татсан дараах асуудлуудад дараагийн аудитаар горим сорил хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Үүнд:

1. Засгийн газрын 2013 оны 346 дугаар тогтоолоор Японы улсын буцалтгүй тусламжаар сургалтын эмнэлэг байгуулахаар төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэж, 2016 онд Монгол Улс болон Япон Улсын Засгийн газрын тэргүүнүүд их сургуулийн дэргэдэх эмнэлэг байгуулах гэрээг үзэглэж, улмаар БСШУЯ /хуучнаар/ ЭМЯ, Жайка ОУБ, АШУҮИС нь сургалтын эмнэлэг байгуулах “Санамж бичиг” байгуулсан байна. Уг баримт бичгүүдийг үндэслэн Засгийн газрын 2019 оны 53, 2020 оны 98 дугаар тогтоолуудаар БСШУЯ-ны /хуучнаар/ эрхлэх асуудлын хүрээнд АШУҮИС-ийн Монгол-Японы эмнэлгийг байгуулж, үйл ажиллагааг эхлүүлсэн. Япон Улсаас дээрх гэрээ, санамж бичигт заасны дагуу дэлхийн жишигт нийцсэн их сургуулийн зориулалт бүхий барилга, эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг нийлүүлэх зорилгыг тавьж, гэрээний үүргээ хангасан ба төслийн зорилгод нийцсэн үйл ажиллагаа явуулах боломж бүрдсэн гэж үзсэн ба Монгол-Япон эмнэлгийг байгуулах, төсөл хөтөлбөрийн үндсэн зорилго нь АШУҮИС-ийн эмнэлгийг байгуулж, суралцагч-оюутнуудыг мэргэшүүлэх, дадлагажуулах зорилгоор хөрөнгө оруулалт хийсэн зорилгыг хангаж, үйл ажиллагаа явуулж байгаа эсэх, төсөл, санамж бичгийн зорилгын хэрэгжилт хэрхэн хангагдаж байгааг анхаарах;
2. Тайлант онд шинээр боловсруулан баталсан “Эмнэлгийн байгууламж, тоног төхөөрөмжийн эрсдэлийн сангийн журам” болон “Болзошгүй эрсдэлийн сангийн үйл ажиллагааны заавар”-т тусгагдсан хувь хэмжээг хэт өндрөөр баталсан нь эх үүсвэр дутагдал үүсэх эрсдэлтэй байна;
3. Засгийн газрын сан 166,036,081.2 мянган төгрөгөөр өссөнийг улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрчлөлт оруулаагүй байна;
4. Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг сайжруулахтай холбоотой дараах саналуудыг хүргүүлж байна. Үүнд:
 - Журмын хоёрдугаар хавсралтаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт болон Сангийн яамны finperform.mof.gov.mn сайт дахь маягт хоорондын зөрүүг арилгах.
 - Журмын гуравдугаар хавсралтаар батлагдсан дансны жишиг жагсаалтыг дээрх Сангийн яамны шинэ цахим системтэй уялдуулах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,450,460.7 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа:

- Санхүүгийн үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд үндсэн үйл ажиллагааны орлого, төсөвт байгууллагаас санхүүжих санхүүжилт зэргийг ангилал зөрүүлэн тайлагнасан;
- Мөнгөн гүйлгээний тайланд нэмэлт санхүүжилтийн дансны орлого болон төвлөрүүлэх шилжүүлгийг тайлагнаагүй;
- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн орлого, зарлагын гүйлгээг 37,531.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;
- Мөнгөн гүйлгээний тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон нэмэлт санхүүжилтийн тайлан нь хоорондоо уялдаагүй буюу 22,454.4 мянган төгрөгийн орлого, 80.9 мянган төгрөгийн зарлагын дүнгээр зөрүүтэй;
- Үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн дүн нь санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй орлогын дүнгээс 143,386.8 мянган төгрөгөөр зөрүүтэй;
- Үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн шинээр худалдаж авсан хөрөнгийн дүн нь мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгийн зардлын дүнгээс 1,247,007.5 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа зэрэг нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга 1.27-т Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой гэсэн заалттай нийцээгүй байсныг залруулсан.

Аудитаар нийт 1,112,086.2 мянган төгрөгийн 8 зөрчил² илэрсэнд 665,356.2 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 446,730.0 мянган төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 1,112,086.2 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 301,183.6 мянган төгрөгөөс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.2 Албан шаардлага

1. Өмнөх оны аудитаар үндсэн хөрөнгийн дансанд бодит үнэ цэнээр нь бүртгээгүй хөрөнгүүдийг холбогдох газарт уламжлан үнэлж, бүртгэлд тусгах аудитын шийдвэрийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Нягтлан бодох бүртгэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

байх", 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь бүртгээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

2. Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр авахаар нэхэмжилсэн санхүүжилтээс шинжилгээ оношилгооны бүрдэл дутуу, өвчтөн эмнэлгийн тусламж үйлчилгээ авч байх явцдаа өөр эмнэлгээр үйлчлүүлсэн, өвчний түүхийн бичилт шаардлага хангаагүй зэрэг зөрчилтэй асуудлаас шалтгаалан тусламж үйлчилгээний чанарын хяналтаар өмнөх онд 366,565.1 мянган төгрөгийн санхүүжилт хасагдсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн боловч тайлант онд 196,143.1 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй Бүртгэл, даатгал, статистикийн албаны даргад хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулах албан шаардлага хүргүүлэв.

3. Тайлант онд 469,213.1 мянган төгрөгийн эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендерийн батлагдсан төсөвт өртгийг хувааж, сонгон шалгаруулалт явуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулж байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд 33 харилцагчид үйлчилгээ үзүүлсний орлогын төлбөрийн баримтыг 137,455.9 мянган төгрөгөөр дутуу, 230 харилцагчид 227,013.2 мянган төгрөгийн төлбөрийн баримтыг илүү шивж олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг

хориглоно”, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2 “хэрэглэгчийн системийн дамжуулсан мэдээллийг үндсэн системийн санд бүрэн, үнэн зөв нэгтгэх, эрх бүхий этгээдэд тайлагнах”, 17.3 “Албан татвар суутган төлөгч доор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ”, 17.3.1 “албан татвар төлөгчийн хийсэн төлбөр тооцооны мэдээллийг хэрэглэгчийн системд төлбөр хийсэн тухай бүр бүртгэнэ”, 17.3.2 “бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”, 17.5 “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримт олгохоос татгалзах, хуурамч буюу хийгдсэн төлбөр тооцооноос өөр дүнтэй төлбөрийн баримт олгохыг хориглоно”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үйл ажиллагааны орлогын төлбөрийн баримтыг харилцагчдад үнэн зөв, зөрүүгүй шивж олгох

2. Цалин хөлстэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Түүврээр 3 дугаар сарын цагийн бүртгэлийг хянахад 18 ажилтан цагийн бүртгэлийн системд 7-149 цаг ажилласнаар бүртгэгдсэн байхад цалинг олгохдоо 168 цаг ажилласнаар тооцсон нь цаг бүртгэлийн төхөөрөмжийн бүртгэлд үндэслэн цалинг олгодоггүй, албан хаагчид цагийн бүртгэлийн төхөөрөмжид бүртгүүлж хэвшээгүй байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 "ажил үүргээ биечлэн, үнэнчээр, өөрийн ур чадвар, боломжоо дайчлан зохих ёсоор гүйцэтгэх", 42.2.2 "хөдөлмөрийн хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг дагаж мөрдөх, ажлын цагийг баримтлах, ажлын цагийг гагцхүү ажил үүргээ гүйцэтгэхэд зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажилчдын ажилласан цагийг тооцохдоо цагийн бүртгэлийг системийг үндэслэн цалинг тооцож олгох

Илрүүлэлт: Тайлант онд 39 удаагийн гүйлгээгээр 15,944.9 мянган төгрөгийн шагнал урамшууллын олгохдоо нийгмийн даатгалын шимтгэл болох 3,826.8 мянган төгрөг, хувь хүний орлогын албан татварын 1,411.1 мянган төгрөгийг тус тус суутгаагүй олгосон байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4 “үндсэн ажлаас бусад хуулийн этгээд, хүнээс олгосон энэ хуулийн 19.1.1-д заасан цалин хөлс, олговор” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шагнал, урамшуулалд олгож буй цалингийн нэмэгдлээс хуульд заасны дагуу нийгмийн даатгалын шимтгэл, татварыг суутгаж олгох

3. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээг цахим төлбөрийн баримттай тулган шалгахад 6 харилцагчийн 31,459.5 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ төлбөрийн баримтаар баталгаажгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авалтын гүйлгээг төлбөрийн баримтаар бүрэн баримтжуулж, баримтын бүрдэлгүй зардал гаргахгүй ажиллах

Илрүүлэлт: Монгол Улсын Ерөнхий сайдын 5 дугаар албан даалгаврыг зөрчиж 45,563.5 мянган төгрөгийг шагнал урамшуулал олгох, эд хогшил худалдан авахад зарцуулсан байна.

Энэ нь Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаартай албан даалгаврын 1 дүгээр зүйлийн 1.4.2 "байгууллагын дотоод журмаар олгодог нэг удаагийн тэтгэмж, урамшууллыг түр зогсоох", 1.4.3 "Тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж, бичиг хэргийн зүйлс худалдан авахгүй байх" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан заавар, журам, албан даалгаврыг хэрэгжүүлж ажиллах, төсвийг хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулахгүй байх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Санхүүгийн үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд үндсэн үйл ажиллагааны орлого, төсөвт байгууллагаас санхүүжих санхүүжилт зэргийг ангилал зөрүүлэн тайлагнасан	1				1		1					
2	Мөнгөн гүйлгээний тайланд нэмэлт санхүүжилтийн дансны орлого болон төвлөрүүлэх шилжүүлгийг тайлагнаагүй	1		1				1					
3	Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн орлого, зарлагын гүйлгээг 37,531.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан	1	37,531.1			1	37,531.1	1	37,531.1				
4	Мөнгөн гүйлгээний тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон нэмэлт санхүүжилтийн тайлан нь хоорондоо уялдаагүй буюу 22,454.4 мянган төгрөгийн орлого, 80.9 мянган төгрөгийн зарлагын дүнгээр зөрүүтэй	1	22,535.3			1	22,535.3	1	22,535.3				
5	Үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн дүн нь санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй орлогын дүнгээс 143,386.8 мянган төгрөгөөр зөрүүтэй	1	143,386.8			1	143,386.8	1	143,386.8				
6	Үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн шинээр худалдаж авсан хөрөнгийн дүн нь мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгийн зардлын дүнгээс 1,247,007.5 мянган төгрөгөөр зөрүүтэй	1	1,247,007.5			1	1,247,007.5	1	1,247,007.5				
	Дүн	6	1,450,460.7	1	0.0	5	1,450,460.7	6	1,450,460.7	0	0.0	0	0.0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Өмнөх оны аудитаар өгсөн үндсэн хөрөнгийн дансанд бодит үнэ цэнээр нь бүртгээгүй хөрөнгүүдийг холбогдох газарт уламжлан үнэлж, бүртгэлд тусгах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	1				1					
2	Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр авахаар нэхэмжилсэн санхүүжилтээс шинжилгээ оношилгооны бүрдэл дутуу, өвчтөн эмнэлгийн тусламж үйлчилгээ авч байх явцдаа өөр эмнэлгээр үйлчлүүлсэн, өвчний түүхийн бичилт шаардлага хангаагүй зэрэг зөрчилтэй асуудлаас шалтгаалан тусламж үйлчилгээний чанарын хяналтаар өмнөх онд 366,565.1 мянган төгрөгийн санхүүжилт хасагдсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн боловч тайлант онд 196,143.1 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргасан байна.	1	196,143.1							1	196,143.1
3	Тайлант онд 469,213.1 мянган төгрөгийн эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендерийн батлагдсан төсөвт өртгийг хувааж, сонгон шалгаруулалт явуулсан байна.	1	469,213.1			1	469,213.1				
4	Тайлант онд 33 харилцагчид үйлчилгээ үзүүлсний орлогын төлбөрийн баримтыг 137,455.9 мянган төгрөгөөр дутуу, 230 харилцагчид 227,013.2 мянган төгрөгийн төлбөрийн баримтыг илүү шивж олгосон байна.	1	364,469.1					1	364,469.1		
5	Түүврээр 3 дугаар сарын цагийн бүртгэлийг хянахад 18 ажилтан цагийн бүртгэлийн системд 7-149 цаг ажилласнаар бүртгэгдсэн байхад цалинг олгохдоо 168 цаг ажилласнаар тооцсон нь цаг бүртгэлийн төхөөрөмжийн бүртгэлд үндэслэн цалинг олгодоггүй,	1						1			

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлгийн
2025 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	албан хаагчид цагийн бүртгэлийн төхөөрөмжид бүртгүүлж хэвшээгүй байна.										
6	Тайлант онд 39 удаагийн гүйлгээгээр 15,944.9 мянган төгрөгийн шагнал урамшууллын олгохдоо нийгмийн даатгалын шимтгэл болох 3,826.8 мянган төгрөг, хувь хүний орлогын албан татварын 1,411.1 мянган төгрөгийг тус тус суутгаагүй олгосон байна.	1	5,237.9					1	5,237.9		
7	Мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээг цахим төлбөрийн баримттай тулган шалгахад 6 харилцагчийн 31,459.5 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ төлбөрийн баримтаар баталгаажгаагүй байна.	1	31,459.5					1	31,459.5		
8	Монгол Улсын Ерөнхий сайдын 5 дугаар албан даалгаврыг зөрчиж 45,563.5 мянган төгрөгийг шагнал урамшуулал олгох, эд хогшил худалдан авахад зарцуулсан байна.	1	45,563.5					1	45,563.5		
	Дүн	8	1,112,086.2	0	0.0	2	469,213.1	5	446,730.0	1	196,143.1

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Албан шаардлага		Хариуцлага тооцох албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
1	Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мөн Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 14 удаагийн 98,701.7 мянган төгрөгийн орлого, 15 удаагийн 162,010.8 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ, мөн “Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг” зэргийг мэдээлээгүй байна.	1	260,712.5					1	260,712.5
	Дүн	1	260,712.5	0	0.0	0	0.0	1	260,712.5
	Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
1	Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлагдсан маягтаар бэлтгээгүй, Тендерийн баримт бичигт шалгарсан оролцогчийн тендерт ирүүлсэн материалыг хавсаргаагүй, шалгараагүй оролцогчдын материалыг давхардуулан их хэмжээгээр хувилж хавсарган бичиг хэргийн үргүй зардал гаргасан.	1		1					
2	Тендер шалгаруулалтын баримт бичигт бараа нийлүүлэх хугацааг 14-21 хоногоор заасан боловч гэрээ байгуулахдаа хугацааг 1 жилээр болгон өөрчилж, батлагдсан тендерийн баримт бичгийг мөрдөж ажиллаагүй байна. Мөн тоног төхөөрөмж хүлээн авсан комиссын акт, зарлагын баримт зэргийг гэрээ дүгнэсэн актад хавсаргаагүй байна.	1		1					
3	Эмнэлгийн тавилга, эд хогшил худалдан авах 129,415.5 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй тендерийг үнэлэхдээ ажлын 5 хоногийн дотор дуусгавар болгох байтал тендер нээснээс хойш 7-18 хоногийн дараа үнэлж, сонгон шалгаруулалт хийсэн байна.	1	129,415.5	1	129,415.5				
	Дүн	3	129,415.5	3	129,415.5	0	0.0	0	0.0
	Нийт дүн	4	390,128.0	3	129,415.5	0	0.0	1	260,712.5



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 324/А0150458

Улаанбаатар хот

САГ-2026/11/НА-СТА-ТШЗ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр авахаар нэхэмжилсэн санхүүжилтээс шинжилгээ оношилгооны бүрдэл дутуу, өвчтөн эмнэлгийн тусламж үйлчилгээ авч байх явцдаа өөр эмнэлгээр үйлчлүүлсэн, өвчний түүхийн бичилт шаардлага хангаагүй зэрэг зөрчилтэй асуудлаас шалтгаалан тусламж, үйлчилгээний чанарын хяналтаар 366,565,100.00 /гурван зуун жаран зургаан сая таван зуун жаран таван мянга нэг зуун/ төгрөгийн санхүүжилт хасагдсан зөрчилд өмнөх оны аудитаар албан шаардлага хүргүүлсэн боловч тайлант онд 196,143,086.00 /нэг зуун ерэн зургаан сая нэг зуун дөчин гурван мянга наян зургаан/ төгрөгийн зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ”-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй Бүртгэл, даатгал, статистикийн албаны дарга /Д.Эрдэнэчимэг/-т хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2026 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлгийн захирал /П.Баясгалан/-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Т.ОДОНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 325/АД150458

Улаанбаатар хот

САГ-2026/11/НА - СТА - ТИЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эмнэлгийн тавилга, эд хогшил худалдан авах 129,415,517.00 /нэг зуун хорин есөн сая дөрвөн зуун арван таван мянга таван зуун арван долоон/ төгрөгийн төсөвт өртөгтэй тендерийг үнэлэхдээ ажлын 5 хоногийн дотор дуусгавар болгох байтал тендер нээснээс хойш 7-18 хоногийн дараа үнэлж, сонгон шалгаруулалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2 "Үнэлгээний хороо тендер нээсэн өдөр тендер хянан үзэх, үнэлэх ажиллагааг эхлүүлнэ", Сангийн сайдын 2023 оны А/255 дугаар тушаалын хавсралт "Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар"-ын 1.6 "Захиалагч тендер шалгаруулалтыг хуулийн хугацаанд багтаан хурдан шуурхай зохион байгуулахын тулд тендерийг хянан үзэх, үнэлэх ажиллагааг тендер нээсэн өдөрт нь багтаан эхлүүлж, ажлын таван өдрийн дотор дуусгавар болгох зарчмыг баримтална" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тендерийн үнэлгээг хуульд заасны дагуу тендер нээсэн өдрөөс эхэлж үнэлдэггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлгийн захирал /П.Баясгалан/, санхүү, төлөвлөлтийн албаны дарга /Д.Баярсайхан/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Т.ОДОНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 326/А0150458

Улаанбаатар хот

САГ - 2026/11/НА - СТА - ТЦУЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тендер шалгаруулалтын баримт бичигт бараа нийлүүлэх хугацааг 14-21 хоногоор заасан боловч гэрээ байгуулахдаа хугацааг 1 жилээр болгон өөрчилж, батлагдсан тендерийн баримт бичгийг мөрдөж ажиллаагүй, тоног төхөөрөмж хүлээн авсан комиссын актыг гэрээ дүгнэсэн актад хавсаргаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 "Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, захиалагч батална, 11.12 "Тендер шалгаруулалтын баримт бичигт өөрчлөлт оруулсан тухай бүрд цахим системийн холбогдох хэсэгт өөрчлөлтийг тусгана" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг тендерийн баримт бичигт заасны дагуу гүйцэтгээгүй, гэрээний биелэлтийг дүгнээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлгийн захирал /П.Баясгалан/, санхүү, төлөвлөлтийн албаны дарга /Д.Баярсайхан/ нар т даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

(Handwritten signatures)

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Т.ОДОНЧИМЭГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 327/АД150458

Улаанбаатар хот

САГ-2026/11/НА-СТА-ТЦУЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлагдсан маягтаар бэлтгээгүй, тендерийн баримт бичигт шалгарсан оролцогчийн тендэрт ирүүлсэн материалыг хавсаргаагүй, шалгараагүй оролцогчдын материалыг давхардуулан их хэмжээгээр хувилж хавсарган төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4 "цахим гарын үсэг, цахим шуудан ашиглах зэргээр албан бичиг боловсруулах, илгээх үйл явцыг хялбаршуулж бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хор, шуудан хүргэлтийн зардлыг хэмнэх", Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаал "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-аар баталсан төлөвлөгөө тайлангийн хавсралт маягтууд, 2023 оны А/255 дугаар тушаал "Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар", 2023 оны А/254 дүгээр тушаал "Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам"-ын 2.14 "Үнэлгээний хорооны гишүүн хуулийн 52.1-т заасан үүргийг дараах байдлаар хэрэгжүүлнэ. Үүнд: 2.14.1. үнэлгээний хорооны гишүүнээр томилогдохоос өмнө, эсхүл томилогдсон даруйд Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл"-ийн загварын дагуу тухайн худалдан авах ажиллагаанд оролцоход ашиг сонирхлын зөрчилтэй эсэхээ мэдэгдэх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлагдсан маягтаар бэлтгээгүй, бичиг хэргийн үргүй зардал гаргаж байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлгийн захирал /П.Баясгалан/, санхүү, төлөвлөлтийн албаны дарга /Д.Баярсайхан/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

С.В.

Ц.Наранчимэг

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Т.ОДОНЧИМЭГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 328/А0150458

Улаанбаатар хот

САГ-2026/11/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитаар үндсэн хөрөнгийн дансанд бодит үнэ цэнээр нь бүртгээгүй хөрөнгүүдийг холбогдох газарт уламжлан үнэлж, бүртгэлд тусгах аудитын шийдвэрийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Нягтлан бодох бүртгэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10 "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үндсэн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь бүртгээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлгийн захирал /П.Баясгалан/, санхүү, төлөвлөлтийн албаны дарга /Д.Баярсайхан/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

С.О.В.



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Т.ОДОНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 329/А0150458

Улаанбаатар хот

САГ-2026/11/НА - СТА - ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 469,213,086.00 /дөрвөн зуун жаран есөн сая хоёр зуун арван гурван мянга наян зургаан/ төгрөгийн эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендерийн батлагдсан төсөвт өртгийг хувааж, сонгон шалгаруулалт явуулсан байна.


Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулж байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлгийн захирал /П.Баясгалан/, санхүү, төлөвлөлтийн албаны дарга /Д.Баярсайхан/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Т.ОДОНЧИМЭГ